



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

# МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2014 оны 6 дугаар сар

---

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</b></p> <p><b>Газрын дарга</b> С.Төмөрхүү</p> <p><b>Аудитын менежер</b> Д.Баттулга Г.Гүнжидмаа Л.Эрдэнэчулуун</p> <p><b>Ахлах аудитор</b> Д.Гандолгор Д.Цэрэндорж С.Сэрчхорол Ш.Энхтайван Ц.Гэрэл Ж.Батсайхан Б.Болормаа</p> <p><b>Аудитор</b> Ц.Цолмон Б.Нямхүү Л.Авирмэд С.Батсүх Ж.Ядмаа Л.Мөнхцацрал Б.Сэржмядаг Д.Будмаа</p> <p><b>2014 оны 6 дугаар сар</b></p> <p><b>Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:</b> <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i></p> <p><b>ХАЯГ: Үндэсний аудитын газар</b></p> <p><i>Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс</i></p>	<p style="text-align: center;"><b>АГУУЛГА</b></p> <p><b>Товчилсон үгийн жагсаалт</b> <span style="float: right;"><b>2</b></span></p> <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b> <span style="float: right;"><b>3</b></span></p> <p><b>БҮЛЭГ 1</b> <b>Монгол Улсын 2013 оны төсвийн бүрэлдэхүүн, онцлог, ТХМ-ийн шалгуур үзүүлэлт</b></p> <p><b>1.1</b> Монгол Улсын 2013 оны төсвийн зорилт <span style="float: right;"><b>5</b></span></p> <p><b>1.2</b> Монгол Улсын 2013 оны төсвийн бүрэлдэхүүн</p> <p><b>1.3</b> Монгол Улсын 2013 оны төсвийн онцлог <span style="float: right;"><b>5</b></span></p> <p><b>1.4</b> Улсын нэгдсэн төсвийн шалгуур үзүүлэлт <span style="float: right;"><b>6</b></span></p> <p><b>БҮЛЭГ 2</b> <b>Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл</b></p> <p><b>2.1</b> Нэгдсэн төсвийн орлого <span style="float: right;"><b>7-9</b></span></p> <p><b>2.2</b> Улсын төсвийн орлого <span style="float: right;"><b>9-11</b></span></p> <p><b>2.3</b> Орон нутгийн төсвийн орлого <span style="float: right;"><b>11-13</b></span></p> <p><b>2.4</b> Хүний хөгжил сангийн орлого <span style="float: right;"><b>13-14</b></span></p> <p><b>2.5</b> Нийгмийн даатгалын сангийн орлого <span style="float: right;"><b>14-15</b></span></p> <p><b>БҮЛЭГ 3</b> <b>Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл</b></p> <p><b>3.1</b> Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт <span style="float: right;"><b>15-20</b></span></p> <p><b>3.2</b> Улсын төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл <span style="float: right;"><b>20-22</b></span></p> <p><b>3.3</b> Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл <span style="float: right;"><b>22-23</b></span></p> <p><b>3.4</b> Хүний хөгжил сангийн зардлын гүйцэтгэл <span style="float: right;"><b>23-24</b></span></p> <p><b>3.5</b> Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл <span style="float: right;"><b>24-25</b></span></p> <p><b>3.6</b> Нэмэлт төсвийн гүйцэтгэл <span style="float: right;"><b>25-25</b></span></p> <p><b>БҮЛЭГ 4</b> <b>Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн талаар</b> <span style="float: right;"><b>25-27</b></span></p> <p><b>БҮЛЭГ 5</b> <b>Дүгнэлт</b> <span style="float: right;"><b>27</b></span></p> <p><b>БҮЛЭГ 6</b> <b>Зөвлөмж</b> <span style="float: right;"><b>28</b></span></p> <p><b>Хавсралт</b> <span style="float: right;"><b>29-31</b></span></p>
--	---

### Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕС	Ерөнхий сайд
ЗГ	Засгийн газар
ЗТС	Зам тээврийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ӨННАТ	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны татвар
ХС	Хөдөлмөрийн сайд
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТСГ	Төрийн сангийн газар
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТХ	Татварын хэлтэс
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
УТ	Улсын төсөв
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХЗС	Хууль зүйн сайд
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭХС	Эрчим хүчний сайд

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төсвийн тухай хуулийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2014 оны 5 дугаар сарын 12-ноос 6 дугаар сарын 9-ны өдрүүдэд аудит хийв.

### Аудитын зорилт

Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

### Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12.1.7-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны гүйцэтгэлийн танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын эдийн засгийн 2013 оны төлөв байдал
- Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл
- Хүний хөгжил сангийн төсвийн 2013 оны гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2013 оны гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2013 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

### Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаасны хөрөнгө, ЗГ-ын баталгаа гаргасан үнэт цаасны хөрөнгөөр хийгдсэн төслийн гүйцэтгэл
- Чингис бондын эх үүсвэрээс 2013 онд олгосон санхүүжилтийн мэдээ
- Хөгжлийн банкны эх үүсвэрээс 2012, 2013 онуудад олгосон санхүүжилт
- Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын 2013 оны төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл
- Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- Монгол Улсын 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
- Монгол Улсын 2013 оны төсвийн зарлагын гүйцэтгэл
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- 2013 оны нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэл
- Орон нутгийн 2013 оны төсвийн орлого, зарлага, татаасын товчоо
- Орон нутгийн 2013 оны төсвийн гүйцэтгэл
- Хүний хөгжил сангийн төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- ТЭЗ нарын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнгийн тайланг тус тус харуулсан байна.

Сангийн сайдын 2009 оны 171 үдээр тушаалаар баталсан “Улс, орон нутгийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын 1.3-д “Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг мөнгөн суурьтай бүртгэлийн зарчмаар хүлээн зөвшөөрч тайлагнана” гэж заасны дагуу СЯ-ны Төрийн сангийн газраас Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг мөнгөн сууриар тооцож тайлагнасан байна.

### **Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, шинжилгээ хийх зэрэг аудитын аргачаар ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### **Хүндрэл бэрхшээл**

Аудит хийх явцад дараах хүндрэл гарч байв.

- Төсвийн тухай хуулиар Сангийн Яам 4 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 10-ны дотор бүх төсөв захирагч нарын тайланг нэгтгэсэн байх, Үндэсний Аудитын газар 5 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 10-ны дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж УИХ-д танилцуулахаар хуульчлагдсан нь цаг хугацааны хувьд ихээхэн шахуу болж аудитын дүн шинжилгээ хийх цаг хугацаа хомс байгаа нь аудитын чанарт нөлөөлөхөөр байна.

## **БҮЛЭГ 1. Монгол Улсын 2013 оны төсвийн бүрэлдэхүүн, онцлог, ТХМ-ийн шалгуур үзүүлэлт**

### 1.1 Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн зорилт:

- Төсвийн тусгай шаардлагуудыг хангаж, зорилтот түвшинд хүргэх;
- Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлэх, санхүүгийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх,
- ДНБ-д ногдох төсвийн зарлагын хэмжээг жил бүр бууруулах
- Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бололцоотой эх үүсвэрийг бүрэн дайчлах,
- Төсвийн үргүй зардлыг багасгах болон хөрөнгийг арилжааны банкинд байршуулах, хадгалуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангахүйөрхоряныг боловсронгуй болгох,
- Төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэх, тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрүүлэх, үр өгөөжтэй хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах зорилготой байжээ.

1.2 Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн. Монгол Улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв гэсэн 4 хэсгээс бүрдэж байна.

### 1.3 Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн онцлог.

- Төсвийн тухай хууль болон Нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд 2013 оноос эхлэн бүрэн хэрэгжиж эхэлсэн;
- 2013 оны төсвийн зарлагын өсөлтийг зохистой түвшинд тогтоох зорилгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай байхаар төлөвлөж гүйцэтгэлийг тооцсон;
- 2013 оноос тухайн орон нутгийн ИТХ орон нутгийн онцлог байдалтай уялдуулан төлбөр, хураамжийн хувь хэмжээг өөрөө тогтоож, тогтоосон хувь хэмжээ нь төлбөр, хураамжийн доод хязгаараас давсан тохиолдолд тус орлогыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, өөрөө захиран зарцуулах боломжтой болсон;
- Тайлант оноос Төсвийн тухай хуулийн 59.1.2-д “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувиас бүрдэнэ” гэсэн заалт хэрэгжиж эхэлсэн;
- 2013 онд анх удаа Төсвийн тухай хуулийн 47.2 -д заасны дагуу нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны тайланг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болгон тусад нь тайлагнасан;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-д заасны дагуу 2013 оны хувьд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн улсын өр ДНБ-ий 50.0 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг баримталсан.

**ТХМ-ийн шалгуур үзүүлэлт.**

1.4. 2013 оны нэгдсэн төсөв УИХ-аас баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос бусад үзүүлэлт хангаж байна.

*ТХМ-ийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хүснэгтээр харуулбал:*

	Шалгуур үзүүлэлтүүд	2013 оны			тайлбар
		хүрэх түвшин	хүрсэн түвшин	зөрүү	
1	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	40.2	33.8	6.4	2013 онд улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,940.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөнийн биелэлт 459.5 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар тасарсан нь УИХ-аас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.
2	Нэгдсэн төсвийн нийт зарлага (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	42.2	35.1	7.1	Тайлант онд нийт зарлага ба цэвэр зээл 6,164.7 тэрбум төгрөгт хүрч 90.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь УИХ-аас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
3	Нэгдсэн төсвийн тэнцэл (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	-2.0	-1.2	0.8	2013 оны улсын нэгдсэн төсвийн тэнцлийг 360.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснийг багасгаж 224.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь УИХ-аас тогтоосон шалгуурыг хангаж байна
4	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	14.1	8.5	5.6	2013 онд нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-нд эзлэх хэмжээ 8.5 хувьтай гарсан нь УИХ-аас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа мэт боловч санхүүгийн боломжоос шалтгаалан хөрөнгө оруулалтад санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй холбоотой байна.
5	Улсын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	46.0	49.9	3.9	Тайлант онд улсын өрийн нийт хэмжээ өнөөгийн үнэ цэнээр 8,757.5 тэрбум төгрөгт хүрсэн нь УИХ-аас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 3.9 пунктээр илүү байгаа боловч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-д "...улсын нийт өрийн өнөөгийн цэвэр үнэ цэнээр илэрхийлсэн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2013 онд 50 хувиас хэтрүүлэхгүй байна" гэж заасны дагуу шалгуур үзүүлэлтийг хангаж байна.
6	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ (ДНБ-нд эзлэх хэмжээ хувиар)	1.5	1.2	0.3	Тайлант онд нийгмийн халамжийн хуулийн дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээ 214.4 тэрбум төгрөгт хүрсэн нь УИХ-аас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 0.3 пунктээр доогуур байна.

Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

1.5 2013 оны ТХМ-д ДНБ-ий бодитөсөлт 17.6 хувь байхаар тооцсон ч гүйцэтгэлээр 11.7 хувь буюу 5.9 пунктээр бага гарсан байна.

1.6 Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 5,940.1 тэрбум төгрөг болж ДНБ-ий 33.8 хувьд, төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ 6,164.7 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 35.1 хувьд хүрчээ.

1.7 2013 оны нэгдсэн төсвийн зарлага төлөвлөснөөс хэмнэгдсэн боловч төсвийн нийт орлогын төлөвлөгөө 461.7 тэрбум төгрөгөөр тасарчээ.



## БҮЛЭГ 2. Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

### 2.1 Нэгдсэн төсвийн орлого

2.1.1 Монгол Улсын 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн буюу зэс, үүрсний зах зээлийнүнэ ба тэнцвэржүүлсэн үнийн зөрүүгээс орох орлогыг Тогтворжуулалтын санд төвлөрүүлж улмаар нийгэм, эдийн засгийн өгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төсвөөс санхүүжигдэх үйл ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгджээ.

2.1.2 2013 оны улсын нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг төлөвлөхдөө зэс, коксжих болон боловсруулсан чулуун үүрсний тэнцвэржүүлсэн үнийг хүснэгтэд үзүүлснээр тооцсон,

	(үнийн дундаж, тонн ам.доллараар)
Зэс	6328.9
Боловсруулсан нүүрс	131.5
Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	80.2
Чулуун нүүрс (4000-5500ккал)	65.5

- Оюутолгойн гэрээнд нэмэлтөөрчлөлт оруулах хэлэлцээрийг хийснээр тус компаниас ашигт малтмалын ашигласны өлбөрийг авах, мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зарим хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах замаар төсвийн орлогыг 445.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр,
- Оюутолгой компани 2013 онд 382.0 мянган тонн зэсийн баяжмал, 424.0 мянган унци алт, 802.0 мянган унци өнгө олборлож, тус компаниас төсөвт нийт 151.3 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэхээр,
- Гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын орлогыг 1,257.1 тэрбум төгрөгөөр тооцсон байна.

2.1.3 2013 оны төсөвт олон улсын валютын сангаас гаргасан зэс, нүүрсний дундаж үнэ болон “Bloomberg”-ийн мэдээллээс 2010-2013 оны зэс, үүрсний дундаж үнийн төсөөллийг дундажлан зэсийн үнийг 6,328.9 ам.доллар, боловсруулсан үүрсний тэнцвэржүүлсэн үнийг 65.0-131.5 ам.доллараар тооцож төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг баталсан байна.

#### Монгол улсын 2013 оны нэгдсэн төсөвт оруулсан өөрчлөлт

(тэрбум төгрөг)

Эдийн засгийн ангилал	Батлагдсан	Тодотгол <sup>1</sup>	*Тодотгол <sup>1</sup> . Монгол Улсын эдийн засгийн өсөлт төлөөлсөн хэмжээнд хүрэхээргүй болсон, хөрш орон болон дэлхийн зах зээл дээрх нүүрсний эрэлт, үнийн бууралтаас шалтгаалан экспорт тооцоолсон хэмжээнд хүрэхгүй болж эдгээр бүтээгдэхүүнээс төсөвт төвлөрөх орлого багассан ба импортын хэмжээ буурсанаас улсын төсөвт төвлөрөх татварын орлого буурсан, мөн Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүйн улмаас 2013 оны төсөвт төвлөрүүлэхээр тооцсон орлогыг төвлөрүүлэх боломжгүй болжээ./2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,258.10	6,448.60	
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	169.8	49.0	
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,088.30	6,399.60	
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	7,087.60	6,397.50	
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.8	2.1	
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0	0	

2.1.4 Ийнхүү экспортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр буурсаныг үндэслэл болгон УИХ-аас төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээг анх баталсан хэмжээнээс 809,5 тэрбум төгрөгөөр бууруулан тодотгол хийсэн байна.



2.1.5 2013 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн гүйцэтгэлээр 5,986.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөний биелэлт 461.7 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар тасарсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

( тэрбум төгрөг)

Төсвийн орлогын ангилал, зүйл	2013 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,448.6	5,986.9	-461.7	92.8
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	49.0	46.9	-2.0	95.7
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,399.6	5,940.1	-459.5	92.8
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	6,397.5	5,936.7	-460.8	92.7
1. ТАТВАРЫН ОРЛОГО	5,680.1	5,072.8	-607.3	89.3
2. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	717.4	863.9	146.5	120.4
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.1	3.4	1.3	159.5
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0	0	0	0

2.1.6 Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 85.4 хувь нь татварын, 14.6 хувь нь татварын бус болон хөрөнгийн орлогоос бүрдсэн байна.


(тэрбум төгрөг)

2.1.7 Нэгдсэн төсвийн татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үүгийн 5 жилийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал,

ҮЗҮҮЛЭЛТ	2009	2010	2011	2012	2013
ДНБ, оны үнээр	6,590.6	8414.5	10,829.6	14,012.0	17,550.2
Татварын орлого	1620.4	2688.2	3,668.3	4,203.3	5,072.8
Татварын ачаалал, %	24.5	31.9	33.9	30.0	28.9

2.1.8 Дээрх хүснэгтээс харахад 2013 онд ДНБ-д эзлэх татварын орлого 28.9 хувьтай байгаа нь 2011 оныхоос 5.0 пунктээр, 2012 оныхоос 1.1 пунктээр буурч энэ хэмжээгээр эдийн засагт үзүүлэх татварын ачаалал багассан байна.

2.1.9 Манай улсын нийт экспортын 90 орчим хувь, төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байгаа ба сүүлийн 5 жилийн байдлаар уул уурхайн салбарын оруулсан татварын орлогын хэмжээг графикаар харуулбал



2.1.10 Уул уурхайн салбараас орсон татварын орлогын хэмжээ 2013 онд 1,147.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 259.1 тэрбум төгрөгөөр буюу 29.2 хувиар нэмэгдсэн байна.

2.1.11 2013 онд уул уурхайн салбараас төвлөрүүлсэн нийт татварын орлогын 75.8 хувь нь эвхэн зэс, нүүрснээс төвлөрч байгаа бөгөөд үүнээс зэсээс орох татварын хэмжээ орлогын 50.1 хувийг бүрдүүлж байна.

2.1.12 Тайлант онд нүүрсний экспортоос нийт 294.4 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдүүлсэн нь өмнөх оноос 70.6 тэрбум төгрөгөөр буюу 31.6 хувиар нэмэгдсэн байна.

2.1.13 2013 онд гадаад зах зээлээс шалтгаалан 1 тонн зэсийн дунджаар 7,389.0 ам.долларт хэлбэлзэж, тэнцвэржүүлсэн үнээс 1,060.1 ам.доллороор нэмэгдсэн тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах боломж бүрдсэн байна. Тухайлбал, дээрх санд 46.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсний 21.5 хувь буюу 10.8 тэрбум төгрөг нь АМНАТ-өөр, 16.1 хувь буюу 7.6 тэрбум төгрөг нь ААНОАТ-аар, 62.4 хувь буюу 28.5 тэрбум төгрөг нь өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрөөр төвлөрчээ.

## 2.2. Улсын төсвийн орлого

2.2.1 2013 онд Улсын төсвийн орлого ба тусламжийн дүнг 4,606.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,057.3 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 88.1 хувийн биелэлттэй буюу 549.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

(тэрбум төгрөгөөр)

Төсвийн орлогын ангилал, зүйл	2013 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4 606.4</b>	<b>4 057.3</b>	<b>-549.1</b>	<b>88.1</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	49.0	46.9	-2.1	95.7
1. УТ – ААНОАТ	7.6	7.6	0.0	100.0
2. ХХС – АМНАТ	13.3	10.8	-2.5	81.2
3. ХХС – ӨННАТ	28.1	28.5	0.4	101.4
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4 557.5</b>	<b>4 010.4</b>	<b>-547.1</b>	<b>88.0</b>
<b>А. УРСГАЛ ОРЛОГО</b>	4 443.0	3 896.4	-546.6	87.7
<b>I. ТАТВАРЫН ОРЛОГО</b>	3 871.3	3 196.9	-674.4	82.6
1. Орлогын албан татвар	863.8	660.2	-203.6	76.4
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 764.8	1 435.1	-329.7	81.3
3. Онцгой албан татвар	455.8	449.4	-6.4	98.6
4. Тусгай зориулалтын орлого	10.6	10.9	0.3	102.8
5. Гаалийн албан татвар	516.6	381.4	-135.2	73.8
6. Бусад татвар	259.7	259.9	0.2	100.1
<b>II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>571.8</b>	<b>699.6</b>	<b>127.8</b>	<b>122.4</b>
<b>Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>114.4</b>	<b>113.9</b>	<b>-0.5</b>	<b>99.6</b>

2.2.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын 34.7 хувийг дотоодын бараа үйлчилгээний, 65,3 хувийг импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар тус тус эзэлж байна.

2.2.3 Тайлант онд орлогын албан татвар төлөвлөснөөс 203.6 тэрбум төгрөгөөр буурсан нь экспортод гаргасан эрдэс баялгийн үбээгдхүүний дэлхийн зах зээлийн үнэ, үйлдвэрлэлийн болон экспортын хэмжээ буурсантай холбоотой бөгөөд уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого болон экспортын гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал,

Татварын хэмжээ /тэрбум төгрөг/					Экспортлосон хэмжээ				
Бүтээгдэхүүний нэр төрөл	2013 он			зөрүү	Бүтээгдэхүүний нэр төрөл	төлөв	тодот	гүйц	зөрүү
	төлөв	тодот	гүйц						
Алт	95.7	64.4	50.1	-14.3	Алт /тушаасан, экспортлосон. тн/	19.6	13.2	10.4	(2.8)
Нүүрс	263.5	142.0	124.3	-17.7	Нүүрс /экспортлосон сая.тн/	28.0	20.5	18.4	(2.1)
Зэсийн баяжмал	268.8	227.2	269.9	42.7	Зэсийн баяжмал /экспортлосон мян.тн/	990.3	694.3	649.8	(44.5)

Цайрын баяжмал	4.6	6.4	9.5	3.1
Төмрийн хүдэр	111.6	66.9	48.0	-18.9
Жонш, жоншны баяжмал	10.0	2.8	3.3	0.5
<b>Дүн</b>	<b>754.2</b>	<b>509.7</b>	<b>505.1</b>	<b>-4.6</b>

Цайрын баяжмал /экспортлосон мян.тн/	110.8	111.7	130.9	19.2
Төмрийн хүдэр /экспортлосон сая.тн/	9.9	6.0	6.7	0.7
Жонш, жоншны баяжмал /экспортлосон мян.тн/	573.5	287.7	337.8	50.1

2.2.4 АМНАТ-ийн орлогоор 2013 онд 509.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 4.6 тэрбум төгрөгөөр буурсан нь нүүрсний биет хэмжээ 2.1 сая тонноор, алт тушаалтын хэмжээ 2.8 тонноор буурсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

2.2.5 Төлөвлөсөн орлогын биелэлтэд томоохон 173 аж ахуйн нэгж, байгууллага 283.4 тэрбум төгрөгийн ААНОАТ, 149 аж ахуйн нэгж, байгууллага 164.1 тэрбум төгрөгийн НӨАТ дутуу төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

2.2.6 2013 онд татварын байгууллагад тайлан үзүүлэх 92.9 мянган ААНБ -аас 73.5 мянган ААНБ тайлангаа ирүүлж, татварт хамруулалт 79.1 хувьд хүрсэн байна. Гэвч тайлангаа ирүүлсэн ААНБ-ын 49.5 хувь буюу 36.4 мянга нь үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажиллажээ.

2.2.7 Мөн НӨАТ төлөгч 26.2 мянган ААНБ-ын 87.4 хувь нь тайлан ирүүлснээс татвар төлөгчдийн 32.8 хувь буюу 8.6 мянган татвар төлөгч үйл ажиллагаа явуулаагүй “Х” тайлан ирүүлсэн байна.

2.2.8 УИХ-ын 2012 оны 9 дүгээр сарын 11-нд баталсан “Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар онцгой албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн, мөн долларын ханш 1523.9 төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс өссөн нь онцгой албан татварын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

2.2.9 Согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвартай үбээгдэхүүний борлуулалтын хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад архи, дарс, спирт 1.0 сая литр буюу 2.9 хувиар өссөн, пиво 2.0 сая литр буюу 3.3 хувиар, тамхи 281.9 сая ширхэг буюу 20.3 хувиар тус тус буурсан байна.

2.2.10 Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын өнгөлөлт, чөлөөлөлт 2012 онд 474.8 тэрбум төгрөг буюу татварын орлогын 11.3 хувьтай тэнцэж байсан бол 2013 онд 505.4 тэрбум төгрөг буюу татварын орлогын 10.0 хувьд хүрээд байна.

2.2.11 2013 онд татварын орлого 674.4 тэрбум төгрөгөөр тасалсныг нэр төрлөөр нь авч үзвэл орлогын албан татвар 203.6 тэрбум төгрөгөөр, гаалийн албан татвар 135.2 тэрбум төгрөгөөр, НӨАТ 329.7 тэрбум төгрөгөөр, үүний дотор дотоодын барааны НӨАТ 149.8 тэрбум төгрөгөөр, импортын барааны НӨАТ 189.9 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан байна.

### 2.3 Татварын бус орлого

2.3.1 2013 оны өсвийн тодотголоор татварын бус орлогыг 571.6 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 699.6 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 22.0 хувиар давуулан биелүүлжээ.

2.3.2 Татварын бус орлогын 33.9 хувь нь өсвийн байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлого, 26.8 хувь нь газрын тосны орлого, 20.9 хувь нь хүү торгуулийн орлого, 8.4

хувь нь бусад нэр заагдаг орлого, 8.1 хувь нь навигацийн орлого, 1.7 хувь нь хувьцааны ногдол ашгийн орлого эзэлж байна.

2.3.3 Дээрх орлого нийт дүнгээрээ биелсэн боловч зарим байгууллагын орлого тасарсан байна. Тухайлбал,

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан харилцаа холбооны үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдээс 3.6 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 688.7 сая төгрөгөөр буюу 19 хувиар тасалжээ. Энэ нь 257 лиценз эзэмшигч байгууллагаас 97 ААНБ-ын 865.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна. Дээрх авлагыг барагдуулах талаар ҮАГ-аас албан шаардлага өгөв.
- Улсын бүртгэлийн ерөнхий газар орлогын төлөвлөгөөг 2.1 тэрбум төгрөг буюу 13 хувиар тасалсан нь 375.0 мянган ширхэг иргэний цахим нэмлэхийн нэгжийн үнийг 25.0 мянган төгрөгөөр тооцон 7.5 тэрбум төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн ч нэгжийн үнийг бууруулах шийдвэр гарсантай холбоотой байна.
- Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого, хайгуул хийсний нөхөн төлбөрийн орлогоор 43.6 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулахаас гүйцэтгэлээр 39.6 тэрбум төгрөг төвлөрсөн нь тайлант онд 347 тусгай зөвшөөрлийг цуцлан, 253 тусгай зөвшөөрлийг дуусгавар болгосноос 615.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт орох боломж алдагдсан байна.
- Ногдол ашгийн орлогоор 11.6 тэрбум төгрөг төвлөрч төлөвлөгөө 728.5 сая төгрөгөөр давж биелүүлсэн боловч Хөтөлийн цемент шохой ХХК нь 998.6 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй зөрчилд ҮАГ-аас акт тавих нь зүйтэй гэж үзлээ.
- ГЕГ-ын гаалийн бүрдүүлэлтийн “түр горим”-ын дансанд байршиж буй барьцаа хөрөнгийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр тооцогдсон хүү 42.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр ҮАГ-аас акт тавив.

2.3.4 Татварын бус орлогын хүү торгуулийн ангилалд тайлагнасан орлогыг төрлөөр нь ангилж үзэхэд дараах байдалтай байна.

(тэрбум төгрөгөөр)

Орлогын задаргаа	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Эргэж төлөгдөх зээлийн хүүгийн орлого	9,3	8,3	-1,0	89.2
Чингис бондын хүүгийн орлого	71,2	119,6	48,4	167.9
Төрийн сангийн мөнгө хөрөнгийн удирдлагаас олох хүүгийн орлого	1,5	15,1	13,6	1006.7
Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүү, торгуулийн орлого		0,14	0,14	
Цөмийн энергийн газрын хүү, торгуулийн орлого		0,01	0,01	
ТЕГ-ын хүү торгуулийн орлого		3,1	3,1	
<b>Нийт</b>	<b>82,0</b>	<b>146,3</b>	<b>64,2</b>	<b>178,4</b>

2.3.3 Дээрх хүснэгтээс харахад хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөний биелэлт 178.4 хувьтай байгаа нь Чингис бондын өрөнгийг Хөгжлийн банкинд байршуулсантай холбоотой байна.

## 2.4 Орон нутгийн төсвийн орлого

2.4.1 Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Улсын төсвөөс орон нутагт 155.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрт 3 аймгаас 24.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 209.6 тэрбум төгрөгөөр баталжээ.

(тэрбум төгрөг)

2.4.2 Орон нутгийн төсвийн орлогын 2013 оны батлагдсан өсвийг өмнөх онтой харьцуулбал:

Орлогын нэр	Батлагдсан төсөв		Өөрчлөлт
	2012 он	2013 он	
Урсгал орлогын дүн	704.7	733.3	28.6
Татварын орлого	631.6	656.0	24.4
Татварын бус орлого	73.1	77.3	4.2
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	11.1	2.1	-9.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	151.8	1,154.6	1,002.8
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>867.6</b>	<b>1,890.0</b>	<b>1,022.4</b>

2.4.3 Хуулиар орон нутгийн ИТХ-д олгогдсон үрэн эрхэд халдаж ИТХ -ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар төсвийн тодотголыг олон дахин хийх, алдагдалтай төсөв батлах зэрэг ноцтой зөрчил гаргасаар байна. Тухайлбал,

- Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2013 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 7 удаа хийхдээ орон нутгийн нийт орлогыг 25.6 тэрбум, зарлагыг 52.6 тэрбум төгрөгөөр тусгаж, аймгийн тодотгосон төсвийг 27.0 тэрбум төгрөгийн алдагдалтайгаар баталсан байна. Гэвч 2013 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр болон түүнээс хойш гарсан тогтоолуудаар орлого, зарлагыг тэнцүүлсэн төсвийг баталсан байна.

2.4.4 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 2013 онд 1,901.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,043.7 сая төгрөгөөр өссөн ба төлөвлөгөөг 11.7 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.4.5 Орон нутгийн төсвийн орлогын 59.2 хувийг тусламжийн, 35.6 хувийг татварын, 5.0 хувийг татварын бус, 0.2 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүнээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

Орлогын нэр, төрөл	төлөвлөгөө	2013 он гүйцэтгэл	Биелэлт
<b>1. Татварын орлого</b>	<b>655.6</b>	<b>676.7</b>	<b>103.2</b>
1.1. Орлогын албан татвар	438.7	449.0	102.4
1.2. Өмчийн албан татвар	35.6	44.0	123.6
1.3. Дотоодын бараа үйлчилгээний татвар	24.9	25.8	103.9
1.4. Бусад татвар	156.9	157.9	100.6
<b>2. Татварын бус орлого</b>	<b>77.3</b>	<b>95.8</b>	<b>123.9</b>
<b>3. Хөрөнгийн орлого</b>	<b>2.1</b>	<b>3.4</b>	<b>159.5</b>
<b>4. Тусламжийн орлого</b>	<b>1,154.6</b>	<b>1,125.8</b>	<b>97.5</b>
<b>Нийт орлого, тусламжийн дүн</b>	<b>1,890.0</b>	<b>1,901.7</b>	<b>100.6</b>

2.4.6 Орон нутгийн татварын орлого 3.2 хувиар буюу 20.7 тэрбум, хөрөнгийн орлого 59.5 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 23.9 хувиар буюу 18.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн боловч тусламжийн орлого 2.5 хувь буюу 28.8 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

2.4.7 Татварын орлогоор тайлант онд орон нутгийн төсөвт 676.7 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 20.7 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлжээ.

2.4.8 Аймаг, нийслэлийн төсвийн 2013 урсгал орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

Аймаг, нийслэлийн нэр	Төсвийн орлого			Аймаг, нийслэлийн нэр	Төсвийн орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Архангай	5.4	6.1	113.3	Сүхбаатар	8.6	9.9	115.0
Баян-Өлгий	5.3	5.8	109.2	Сэлэнгэ	18.5	16.1	86.9

Баянхонгор	6.1	6.5	105.6	Төв	11.8	13.4	113.5
Булган	18.5	17.5	94.7	Увс	5.4	6.3	116.8
Говь-Алтай	5.2	5.8	111.1	Ховд	8.1	8.2	100.7
Дорноговь	14.5	15.2	104.7	Хөвсгөл	7.4	8.8	118.6
Дорнод	10.7	12.2	114.1	Хэнтий	7.9	9.2	114.9
Дундговь	3.5	4.0	112.8	Дархан-Уул	15.8	16.5	104.3
Завхан	5.9	6.7	113.5	Улаанбаатар	459.9	483.3	105.1
Өвөрхангай	7.4	8.1	108.7	Орхон	40.2	38.9	96.6
Өмнөговь	65.1	73.4	112.8	Говь-Сүмбэр	3.8	4.1	107.6
<b>Бүгд дүн</b>					<b>735.4</b>	<b>775.9</b>	<b>105.5</b>

2.4.9 Урсгал орлогын татварын төлөвлөгөөг Сэлэнгэ аймаг 2.4 тэрбум, Булган аймаг 1.0 тэрбум, Орхон аймаг 1.3 тэрбум өгрөгөөр тасалж, бусад аймгууд 0.2 -23.3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.4.10 Ашигт малтмалын нөөц ашигласны болон өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны өлбөрийн орлогын төлөвлөгөөг 171.0 хувиар буюу 95.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.4.11 Татварын бус орлогын төлөвлөгөөг 23.9 хувь буюу 18.5 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн нь хү, торгуулийн орлого 18.0 хувь, үрээсийн орлог о 17.5 хувь, өсөвт байгууллагын өөрийн орлог о 41.5 хувь, бусад нэр заагдай орлог о 30.3 хувь, өмч хувьчлалын орлого 31.5 хувиар илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

2.4.12 Улаанбаатар хот, Өмнөговь, Орхон аймаг тайлант онд зарлагаас давсан 24.2 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.4.13 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 2012 онд 14 аймагт 151.8 тэрбум төгрөг олгож байсан бол 2013 онд 18 аймагт 155.0 тэрбум төгрөг олгож, өмнөх оноос 3.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн олгожээ.

2.4.14 Орон нутгийн өсвийн орлогын чөлөөт үлдэгдэл 2013 оны эцэст 250.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## 2.5 Хүний хөгжил сангийн орлого

(тэрбум төгрөгөөр)

2.5.1 ХХС-гийн орлогын 2013 оны өсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал,

Ангилал	Анхны төсөө	Тодотголо ор батлагдсан төсөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1. Нийт орлогын дүн</b>	<b>621.4</b>	<b>397.6</b>	<b>393.5</b>	<b>(4.1)</b>
1.1. Хүний хөгжил сангийн тухай хууль (ХХСТХ)-ийн 3.2.1-д заасан орлого (Ногдол ашиг, хувьцаа борлуулсан орлого)	70.0	68.3	68.3	0.0
1.2. ХХСТХ-ийн 3.2.2-д заасан орлого (АМНАТ-ийн улсын төсөвт ногдох хэсэг)	551.4	329.3	325.0	(4.3)
1.3. ХХСТХ-ийн 3.2.4-д заасан эх үүсвэр (Урьдчилгаа төлбөр)	-	-	-	
1.4. Банкны хүүгийн орлого			0.2	0.2


2.5.2 Төсвийн тодотгосон хуулиар уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүн болох

нүүрсний борлуулалтын үнэ болон биет хэмжээ буурсан, Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүйгээс ХХС-д төвлөрөх АМНАТ-ийн орлогын өлөвлөгөөг 222.1 тэрбум төгрөгөөр бууруулж баталжээ.



2.5.3 ХХС-гийн 2013 оны төсвийн тухай хуулиар тус санд 397.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас төлөвлөгөө 98.9 хувийн биелэлттэй буюу 4.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

2.5.4 ХХС-гийн сүүлийн 3 жилийн орлогын үтэц, б түүний хэлбэлзлэлээс харахад тайлант онд ӨННАТ 40.2 тэрбум төгрөгөөр өсч, харин АМНАТ болон ногдол ашгийн орлого 21.6-72.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.



2.5.5 Дэлхийн зах зээлийн зэсийн үнэ буурсанаас “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ий цэвэр ашиг буурсантай холбоотой тайлант онд тус компаний Монголын талын ногдол ашгаар нийт 68.3 тэрбум өгрөг төвлөрүүлсэн нь 2012 он ыхоос 72.9 тэрбум өгрөг өөр буюу 51.7 хувиар буурсан байна.

## 2.6 Нийгмийн даатгалын сангийн орлого

2.6.1 Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг гүндэслэн НДҮЗ-ийн 2013 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын санд 1,240.1 тэрбум төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 2694.8 мянган даатгуулагчаас 1,283.4 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 103.5 хувиар биелүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/


№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	606.0	635.0	29.0	104.8
2	Тэтгэмжийн даатгал	68.9	67.3	1.6	97.7
3	ҮОМШӨ-ний даатгал	73.2	86.7	13.5	118.4
4	Ажилгүйдлийн даатгал	21.1	25.8	4.7	122.2
5	Эрүүл мэндийн даатгал	202.3	204.1	1.8	100.9
6	Төр хариуцах тэтгэвэр	268.6	264.6	4.0	98.5
	<b>Дүн</b>	<b>1,240.1</b>	<b>1,283.5</b>	<b>43.4</b>	<b>103.5</b>

2.6.2 Тайлант онд “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийнхөн тооцох тухай” хуулийг хэрэгжүүлсэн эр даатгуулагчдын тоо 11.8 хувиар, сангийн орлого 3.5 хувиар тус тус өссөн байна.

2.6.3 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн болон цэргийн тэтгэвэр авагчдын төр хариуцах тэтгэврийн орлогыг 268.6 тэрбум өгрөгөөр төл өвлөж, гүйцэтгэлээр 264.6 тэрбум төгрөг олгож, 4.0 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.



2.6.4 2013 онд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 35.4 мянган аж ахуйн нэгж байгууллага шимтгэл өлсөн нь өнгөрсөн онтой харьцуулахад байгууллагын тоо 4.9 мянгаар буюу 16.3 хувь, сайн дураар даатгуулагчдын тоо 46.9 мянган хүнээр буюу 47.0 хувь тус тус нэмэгджээ.



2.6.5 НДҮЗ-ийн 2013 оны 4 дүгээр сарын 18 -ны өдрийн 9 дүгээр тогтоолоор НДС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс 155.0 тэрбум төгрөгийг арилжааны банкинд харилцах хэлбэрээр, 245.0 тэрбум төгрөгийг хадгаламж хэлбэрээр байршуулахаар баталсан байна.

2.6.6 НДС-гийн арилжааны банкинд байршиж байсан хадгаламжийн эхнүлдэгдэл 163.0 тэрбум төгрөгийг тайлант онд нэмэгдүүлэн 245.0 тэрбум төгрөгт хүргэж, хадгаламжийн хүүгээс 25.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

2.6.7 Засгийн газрын 188.1 тэрбум төгрөгийн бондыг буцаан борлуулж, бондын хүүгээс 12.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.


### БҮЛЭГ 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

#### 3.1 Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт

3.1.1 Монгол Улсын 2013 оны төсвийн зарлагын бодлого нь төсвийн үргүй зардлыг багасгах болон төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж, тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрүүлэх, үр өгөөжтэй хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

3.1.2 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны нийт зарлага 6,886.8 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 6,164.7 тэрбум төгрөг зарцуулж, 89.5 хувийн гүйцэтгэлтэй гарсныг өмнөх онтой зэрэгцүүлэн үзүүлбэл:

(тэрбум төгрөгөөр)



\* Төсөв хоорондын шилжүүлгийн гүйлгээг цэвэрлэсэн дүнгээрх нэгдсэн төсвийн гүйцэтгэл

3.1.3 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр өмнөх онд нийт зарлагын 65.7 хувийг улсын, 9.7 хувийг орон нутгийн, 13.9 хувийг ХХС-гийн, 10.7 хувийг НДС-гийн төсөв тус тус эзэлж байсан бол 2013 онд улсын төсвийн эзлэх хувийн жин 10.2 хувиар, орон нутгийн төсвийн эзлэх хувийн жин 19.4 хувиар, НДС-гийн зардлын эзлэх хувийн жин 6.7 хувиар тус тус өсч, харин ХХС-гийн төсвийн эзлэх хувийн жин 9.4 хувиар буурсан байна.

3.1.4 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны зарлагын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь харуулбал:

*(тэрбум төгрөгөөр)*

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутгийн		ХХС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>6886.7</b>	<b>6164.7</b>	<b>5165.6</b>	<b>4683.0</b>	<b>2056.0</b>	<b>1794.1</b>	<b>282.8</b>	<b>278.3</b>	<b>1067.8</b>	<b>1058.1</b>
Урсгал зарлага	4837.0	4552.6	3699.2	3483.9	1478.1	1386.4	282.8	278.3	1062.4	1052.9
Хөрөнгийн зардал	1959.9	1490.7	1376.7	1077.8	577.9	407.7	0.0	0.0	5.4	5.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	89.7	121.3	89.7	121.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

3.1.5 2013 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 2.4 хувийн өсөлттэй гарсан нь улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасарч тодотголоор зарлагыг бууруулснаас шалтгаалжээ.

3.1.6 Мөн зам, дэд бүтцийн ажлуудыг Чингис бондын хөрөнгөнөөс санхүүжүүлсэн нь тэр хэмжээгээр хөрөнгийн зардлын хэмжээг нэмэгдүүлсэн байна.

3.1.6 2013 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн 73.8 хувийг урсгал зардал, 24.2 хувийг хөрөнгийн зардал, 2.0 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

### 3.2 Урсгал зарлага.

3.2.1 Нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагад 4,552.6 тэрбум төгрөг зарцуулж 94.1 хувийн гүйцэтгэлтэйгээс 30.8 хувийг цалин, 21.8 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 5.9 хувийг зээлийн хүүгийн төлбөр, 41.5 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт тус тус зарцуулсан бөгөөд өмнөх онуудтай харьцуулбал:

*/тэрбум төгрөгөөр/*

Зардлын бүлэг	2010		2011		2012		2013	
	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв
Урсгал зарлага	2,256.2	3,334.7	3,236.4	4,664.3	4,428.1	4,837.0	4,552.6	
Цалин	2,256.7	806.6	802.4	1,216.4	1,197.2	1,419.9	1,401.5	
Бараа үйлчилгээний бусад зардал	518.2	715.5	702.0	944.1	855.3	1,142.5	990.5	
Зээлийн хүүгийн төлбөр	42.3	38.1	37.3	151.6	125.9	313.8	270.4	
Татаас ба урсгал шилжүүлэг	1,047.6	1,774.5	1,694.5	2,352.2	2,249.8	1,960.8	1,890.2	

3.2.2 Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс 17 хувиар өссөн нь 2012 онд төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар дунджаар 30.0 хувь өсгөсөнтэй холбоотой байна.

3.2.3 2013 оны байдлаар улсын төсвийн байг ууллагын албан хаагчдын тоо 161136-д хүрч төлөвлөгөөнөөс 20 хүнээр хэтэрсэн бөгөөд үүнээс удирдах ажилтны тоо 406-гаар,

гүйцэтгэх ажилтны тоо 471-ээр, үйлчлэх ажилтны тоо 1109-өөр, нийт дүнгээр 1986-аар хэтэрч, харин гэрээт ажилтны тоог 1966-аар хэмнэсэн байна.

3.1.1 2012 онтой харьцуулвал 2013 онд 5440 орон тоо нэмэгдэж 2012 оны бүтцийн өөрчлөлтөөр хасагдсан 1101 ажилтны орон тоог оруулан тооцвол 2012 оноос 2013 онд улсын төсвийн байгууллагуудад ажилагсдын тоо 6541 -ээр нэмэгдсэн нь цалингийн зардал өсөх нэг шалтгаан болжээ.

**Зээлийн үйлчилгээний төлбөр:**

3.1.2 2013 оны нэгдсэн төсвөөс 304.3 тэрбум өгрөгийн зээлийн хүү төлөхөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 261.1 тэрбум өгрөг буюу 85.8 хувийн биелэлттэй гарчээ. Зээлийн хүүгийн зардлыг бүтцээр нь доорх хүснэтгээр үзүүлбэл:

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2011 оны гүйцэтгэл	2012 оны гүйцэтгэл	2013 оны			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Дотоодын зээлийн хүү /Улсын зээллэгээ, бондын хүү/	10.7	97.7	271.0	228.9	42.1	84.5
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	26.6	28.2	33.3	32.2	1.1	96.7
<b>Зээлийн үйлчилгээний нийт төлбөр</b>	<b>37.3</b>	<b>125.9</b>	<b>304.3</b>	<b>261.1</b>	<b>43.2</b>	<b>85.8</b>

3.1.3 Дотоодын зээлийн хүүний төлбөрт дотоодод гаргасан Засгийн газрын үнэт цаас, Чингис бонд, Хөгжлийн банкны бондын хүү болон хөнгөлөлтийн төлбөрийг тайлагнасан байна.

3.1.4 Засгийн газраас төсвийн улирлын шинж чанартай орлогын дутагдлыг юмхөх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх болон өрийг төлөх зорилгоор 2013 онд нийт 2,597.9 тэрбум өгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг арилжаалсан бөгөөд үүний 1,558.3 тэрбум төгрөгийн үнэтэй үнэт цаасыг тайлант жилд буцаан төлжээ.

/тэрбум төгрөгөөр/

3.1.5 Засгийн газраас Олон Улсын санхүүгийн зах зээлд гаргасан “Чингис бондын” хүүгийн төлбөрт 2013 онд 100.0 тэрбум өгрөгийг төлөхөөр төлөвлөснөөс 98.9 тэрбум өгрөгийг төлж 99.29 хувийн гүйцэтгэлтэй байна.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Чингис бонд /1.0 тэрбум/	82.50	81.52	98.22
Чингис бонд /500.0 сая/	17.50	17.46	99.76
<b>Нийт дүн</b>	<b>100.00</b>	<b>98.98</b>	<b>99.29</b>

**Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр**

3.1.6 Сангийн сайдын 2013 оны төсвийн багцад Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас авч ашиглаж байгаа өргөлөлттэй зээлийн хүүгийн төлбөрт 33.0 тэрбум төгрөг төлөхөөр төлөвлөснөөс 31.9 тэрбум төгрөг төлсөн байна.

3.1.7 Эрүүл мэндийн сайдын багцад тусгасан Үндэсний оношилгоо эмчилгээний өв байгуулах Мон-8 төслийн зээлийн бэлтгэл ажил хангагдаагүйгээс энэ төсөл хэрэгжихгүй болж зээлийн хүүнд 22.2 сая төгрөг төлөхөөр төсөвлөсөн хүүний төлөлт хийгдээгүй байна.

### Татаас ба урсгал шилжүүлгийн зардал

3.1.8 Татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 1 ,895.2 тэрбум төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 1,824.2 тэрбум төгрөг буюу 96.3 хувь, үүнээс улсын төсвөөс олгох татаас 654.0 тэрбум төгрөгөөр төсөвлөгдөж гүйцэтгэлээр 614.7 тэрбум төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: *(тэрбум төгрөгөөр)*

№	Зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Эрчим хүч дулааны алдагдлын татаас	34.0	32.7	96.1
2	Хотын нийтийн тээврийн татаас	53.2	53.2	100.0
3	Бусад татаас, шижүүлэг	330.2	329.9	99.9
4	Улаан буудай, махны татаас	27.0	11.4	42.2
5	Санхүүгийн дэмжлэг	209.6	187.5	89.4
	<b>Нийт дүн</b>	<b>654.0</b>	<b>614.7</b>	<b>94.0</b>

### Улаанбуудай, махны татаасын талаар

3.1.9 Монголбанкны Ерөнхийлөгч, ҮХААС-ын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дүгээр тушаалаар батласан "Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" дэд төлбөр, гүйцэтгэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу "Баатарууд тэнгэр" ХХК-д 1.0 тэрбум, "Эрдмийт" ХХК-д 1.0 тэрбум, "Жаст агро" ХХК-д 9.4 тэрбум, нийт 11.4 тэрбум төгрөг олгожээ.

### Санхүүгийн дэмжлэгийн талаар

3.1.10 Орон нутгийн өгжлийн санд олгох санхүүжилт эд 209.6 тэрбум төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 187.5 тэрбум төгрөг буюу 89.4 хувьтай гарсан байна. (нэг аймгийн орон нутгийн хөгжлийн санд дунджаар 7.6 тэрбум төгрөг олгосон байна.)

3.1.11 Орон нутгийн өгжлийн нэгдсэн сан нь дотоодын НӨАТ, АМНАТ, аймаг, нийслэлээс төвлөрүүлсэн орлогоос тодорхой хувиар бүрддэг бөгөөд дотоодын НӨАТ-ын орлого 20.8 тэрбум төгрөгөөр, АМНАТ -ийн орлого 1.4 тэрбум төгрөгөөр тасарснаас гүйцэтгэл буурсан байна.

### Улсын гадаад өрийн талаар

3.1.12 Засгийн газар хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас 2013 онд 321.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашиглан , гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 130.3 тэрбум төгрөг буюу үүнээс 98.4 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт, 31.9 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт, харин Чингис бондын хүүгийн төлбөрт 98.9 тэрбум төгрөгийг төлж Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2013 оны жилийн эцсийн байдлаар 3,613.2 тэрбум төгрөг, гадаад бондын үлдэгдэл 2,481.1 тэрбум төгрөг, нийт гадаад өрийн үлдэгдэл 6,094.3 тэрбум төгрөг болж нэрлэсэн дүнгээрээ ДНБ-ий 34.7 хувьтай тэнцэж байна.

Гадаад зээлийн үлдэгдэл, *(тэрбум төгрөг)*

Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Хөтөлбөрийн зээл	42.27	0.00	0.00	8.08	50.35	1.4
Төслийн зээл	2,114.72	295.04	65.40	292.59	2,636.95	73.0
Автозамын зээл	438.29	19.07	16.07	90.19	531.47	14.7
Санхүүгийн зээл	336.75	4.14	11.76	63.52	392.66	10.9
ОУВС зээл	3.49	0.00	3.75	0.26	0.00	0.0

Хугацаа хэтэрсэрийн шийдвэрлэлт	0.00	2.85	1.40	0.28	1.73	0.0
Нийт гадаад зээл	2,935.53	321.10	98.38	454.92	3,613.16	59.3
Чингис бонд	2,088.15	-	-	393.00	2,481.15	40.7
Нийт гадаад өр	<b>5,023.68</b>	<b>321.10</b>	<b>98.38</b>	<b>847.63</b>	<b>6,094.31</b>	<b>100.0</b>

3.1.13 2013 онд 318.0 тэрбум төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөснөөс 321.1 тэрбум төгрөгийн зээлийг ашигласныг ТЕЗ-аар харуулбал:

ТЕЗ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Хувийн жин
Монгол Улсын Ерөнхий сайд	5.2	2.0	38.5 %	1.6%
Улсын Их Хурал	0.4	0.6	150.0 %	0.1%
Сангийн сайд	46.6	29.4	63.1 %	14.7%
Барилга хот байгуулалтын сайд	60.6	8.5	14.0 %	19.1%
Боловсрол шинжлэх ухааны сайд	38.5	0.9	2.3 %	12.1%
Зам тээврийн сайд	108.6	263.0	242.1 %	34.2%
Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд	3.3	2.0	60.6 %	1.0%
Хууль зүйн сайд	1.3	0.4	30.8 %	0.4%
Эрүүл мэндийн сайд	21.5	-	0.0 %	6.7%
Эрчим хүчний сайд	12.3	10.7	87.0 %	3.9%
Орон нутгийн засаг захиргаа	19.7	3.6	18.2 %	6.2%
Нийт дүн	<b>318.0</b>	<b>321.1</b>	<b>100.9 %</b>	<b>100.0%</b>

3.1.14 ЭМС-ын багцад тусгагдсан 21.5 тэрбум төгрөгийн зээлийг огт ашиглаагүй, БШУС, БХБС, орон нутгийн засаг захиргаа, ХЗС, ЕС, СС, ЭХС-ын багц 2.3-87.0 хувийн биелэлттэй гарсан нь зээлийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж муу байгааг харуулж байна

### Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл.

3.1.15 Тодотголоор 8 ТЕЗ-ын төсвийн багцад дотоод эх үүсвэрээс 22.4 тэрбум, гадаад эх үүсвэрээс 67.3 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгох, өмнөх онуудад олгосон зээл, бусад эх үүсвэрт 89.7 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталсан байна.

3.1.16 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн төлөвлөгөө, гүйцэтгэл ийг харуулбал:

№	Зээлийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт	
				Дүн	Хувь
1	Эргэж төлөгдөх зээл	22.4	104.7	82.3	467.4
1.1	Дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(51.4)	(27.6)	(23.8)	53.7
1.2	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	62.3	122.1	59.8	195.9
1.3	Төрийн сургалтын сангийн зээлийн эх үүсвэр	11.4	10.3	(1.1)	(90.4)
2	Гадаадын төслийн зээлээс санхүүжих :	67.3	16.6	(50.7)	(24.7)
2.1	Гадаад зээлээс санхүүжүүлэх дамжуулан зээлдүүлэх зээл	67.3	16.6	(50.7)	(24.7)
	<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн</b>	<b>89.7</b>	<b>121.3</b>	<b>31.6</b>	<b>135.2</b>

3.1.17 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн 2013 оны гүйцэтгэлийг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 35.9 хувиар буурсан байна. Энэ нь 2011 онд эргэж төлөгдөх цэвэр зээл 479.7 тэрбум төгрөгт хүртэл өсч байсантай холбоотой байна.

3.1.18 2013 оны өсвийн тухай хуулиар эргэж төлөгдөх гадаад зээлээс ААНБ -д дамжуулан зээлдүүлсэн зээлээс нийт дүнгээрээ 51.4 тэрбум төгрөг төсөвт буцааж төвлөрүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 27.6 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 53.7 хувь буюу 23.8 тэрбум төгрөгөөр тасалдуулсан байна.

3.1.19 Гадаад зээлээс дотоодын ААНБ-д дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь энэ төрлийн зээлийн ангилалд олон жил үргэлжилсэн чанаргүй зээл их байгаатай холбоотой байна.

3.1.20 Дотоод эх үүсвэрээс олгосон зээл ийн эх үүсвэрт 62.3 тэрбум төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 122.1 тэрбум төгрөг зарцуулж, батлагдсан өсвийг 95.9 хувь буюу 59.8 тэрбум төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байна.

3.1.21 Энэ нь дотоод эх үүсвэрээс эргэж төлөгдөх зээл 467.4 хувь буюу 82.3 тэрбум төгрөгөөр хэтэрч гадаад зээлээс дамжуулан зээлдүүлэх зээлийн хэмжээг 24.7 хувь буюу 50.7 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

3.1.22 Дотоод эх үүсвэрээс эргэж төлөгдөх зээлийн хэтрэлт нь Сангийн сайдын төсвийн багцад эргэж төлөгдөх цэвэр зээл -7.6 тэрбум төгрөгөөр батл агдаж гүйцэтгэлээр 38.5 тэрбум төгрөгт хүрсэнтэй холбоотой байна.

3.1.23 Эргэж төлөгдөх цэвэр зээлээс төсөвт төвлөрүүлэх орлогыг доор дурдсан шалтгааны улмаас дутуу төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Анод банкны өсөвт эргэн төлөгдөх ёстой авлагаас тайлант хугацаанд 20.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож төсөв батлагдсан боловч хөрөнгө төвлөрөөгүй,
- Зоос банкны эрх хүлээн авагчаас 58.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан боловч 5.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн,
- Хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанаас 22.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батласан боловч гүйцэтгэлээр 500.0 сая төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлжээ.

3.1.24 Энэ нь банк, хадгаламж зээлийн хоршооны эрсдэлийг төрөөс дааж, найдваргүй авлага үүсгэж байсантай холбоотой юм

## 3.2 Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл

3.2.1 2013 оны өсвийн тухай хуулиар улсын төсвийн зарлагыг анх 5,975.1 тэрбум төгрөгөөр баталж, тодотголоор нийтдээ 809.5 тэрбум төгрөг бууруулж зарлагыг 5,165.6 тэрбум төгрөгөөр баталжээ.

3.2.2 Улсын төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 20.2 хувийг БШУС, 16.2 хувийг СС, 10.9 хувийг ЗТС, 8.9 хувийг ЭМС, 7.7 хувийг ХАХНХС, 7.4 хувийг ХЗС, 3.4 хувийг БХС үлдсэн 25.3 хувийг бусад ТЕЗ-дын зарлага эзэлж байна.

3.2.3 2013 оны улсын төсвийн зарлагын гүйцэтгэлд урсгал зардал 74.4, хөрөнгийн зардал 23.0, цэвэр зээл 2.6 хувийг тус тус эзэлж байгаа бол өмнөх оноос урсгал зардал 5.0 хувь, цэвэр зээл 1.2 хувиар нэмэгдэж, хөрөнгийн зардал 6.2 хувиар буурсан байна.



3.2.4 ТЕЗ-дын багцын дүнгээр төсөв хэтрээгүй ч зарим төсвийн шууд захирагчид төсвөө хэтрүүлсэн байна. Үүнд:

- БОНХС-ын багцын 4 байгууллага 41.7 сая төгрөгөөр
- БХС-ын багцын 1 байгууллага 96.3 сая төгрөгөөр
- БШУС-ын багцын 4 байгууллага 1,703.7 сая төгрөгөөр тус тус төсвөө хэтрүүлсэн байна.

3.2.5 2013 онд улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 4,683.0 тэрбум төгрөг буюу 90.6 хувиар хангагдсан бөгөөд ЗТС батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой байна.

3.2.6 Тус яаманд хэрэгжиж байгаа 8 төслөөс 2013 онд 122.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гадаадын зээлийнүүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 231.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ нь олон улсын нисэх онгоцны буудал барих төслөөс 134.9 тэрбум төгрөгийг илүү санхүүжүүлсэнтэй холбоотой юм.

3.2.7 Засгийн газрын 2013 оны 9 дээр сарын 21 -ний өдрийн 324 дүгээр тогтоолоор зарцуулахаар төлөвлөсөн тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, ашиглаагүй зардлыг хэмнэх, өр, авлага үүсгэхгүй байх, зардал хэмнэх боломжийг дайчлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна.

3.2.8 ТЕЗ-д нь Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалаар баталсан төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-д заасан эрхийн хүрээнд зардлыг бүлэг дотор нь шилжүүлэн зарцуулж багцын дүнгээр төсвөө хэтрүүлээгүй ч гадаад томилолт, гадаад зочны зардал төлөвлөснөөс илүү зарцуулсан байна. Тухайлбал,

ТЕЗ-дын 65 хувь нь гадаад томилолтын зардлыг 2.2-558.3 сая төгрөгөөр, 11 ТЕЗ гадаад зочны зардлыг нийт 1,021.5 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан байна.

УАГ-аас хийсэн судалгаанд хамрагдсан өсөлтт байгууллагын 1341 ажилтан гадаадад томилолтоор ажилласан ба томилолтын зардалд нийт 4.0 тэрбум төгрөг буюу 1 хүнд дунджаар 3.3 сая төгрөг зарцуулсан байна.

3.2.9 Мөн “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2007 оны 349 дүгээр тогтоолд зааснаас бусад автомашин унах эрхгүй 222 албан тушаалтан автомашин ашиглаж байгаа нь судалгаагаар гарсан байна.

3.2.10 Судалгаанд хамрагдсан 432 төсөвт байгууллагууд 2013 оны гүйцэтгэлээр бензин шатахуунд 13.3 тэрбум, сэлбэг хэрэгсэлд 5.9 тэрбум, тээврийн хэрэгслийн даатгалд 0.5 тэрбум, нийт ашиглалтын зардалд 19.7 тэрбум төгрөг зарцуулсан ба жилд дунджаар 1 автомашины ашиглалтын зардал 4.9 сая төгрөг байна.

3.2.11 Тайлант онд худалдаж авсан автомашины судалгаанаар үзэхэд 19 байгууллага өндөр үнэтэй, шатахуун зарцуулалт ихтэй Lexus 570, Land cruiser 200 маркийн автомашин худалдаж авсан байна.

3.2.12 Зарим ТЕЗ-д батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан өрчил гарсан байна. Тухайлбал,

Уул уурхайн сайд

- Газрын тосны газар төрийн сан банкин дахь сургалтын урамшууллын болон төлөөлөгчийг дэмжих сангийн 157.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- АМГ төсвөө батлагдаагүй ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх болон баяр ёслолын зардалд 31.0 сая төгрөг зарцуулсан байна.



3.2.13 Монгол Улсын 2013 оны өсвийн тухай хуулиар ТЕЗ-дын үндсэн чиг үүрэгт хамаарах 101 өтөлбөрийн 304 арга хэмжээг үр дүн, зорилтот түвшин нөөр нь баталсан байна.

3.2.14 ТЕЗ-дын хэрэгжүүлэх өтөлбөрийн төлөвлөлтийн үн дэслэл муу, хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас шалтгаалж хүрэх үр дүнгийн зорилтот түвшин, гүйцэтгэл нь ихээхэн зөрүүтэй байна. Тухайлбал,

- СЗХ-ны даргын багцад санхүүгийн салбарын зохицуулалт хийх өтөлбөрийн хүрээнд олгох зөвшөөрлийн тоог 2185 гэж төлөвлөснөөс гүйцэтгэлээр 316 зөвшөөрөл олгосон, санхүүгийн 39 хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 608-ыг хийсэн,
- БОНХС-ын багцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талбайг 1500 га гэж төлөвлөснөөс гүйцэтгэлээр 100 га-д нөхөн сэргээсэн,
- БШУС-ын багцад сургуулийн өмнөх боловсролын өтөлбөрийн хүрээнд 1211 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулахаар төлөвлөснөөс 945 цэцэрлэг ажилласан,
- Ерөнхий боловсролын сургуульд суралцах хүүхдийн тоог 518.1 мянга гэж тооцсон боловч гүйцэтгэлээр 569.9 мянган хүүхэд хамрагджээ,
- ХЗС-ын багцад улсын бүртгэл мэдээллийн хүрээнд бэлтгэх улсын бүртгэлийн маягтыг 1700.0 мян.ширхэг гэж төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 5429.6 мян.ширхэг байна.

3.2.15 ТЕЗ-дын төлөвлөсөн өтөлбөр, хүрэх үр дүнгийн зорилтын 28.6 хувь буюу 87 нь дутуу, 7.6 хувь буюу 23 нь хэрэгжээгүй байгаа нь ТЕЗ-д хэрэгжүүлэх өтөлбөр, хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг бүрэн хангаж ажиллаагүйтэй холбоотой ч түүнд шаардагдах төсөв, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур зорилтот түвшинг боловсронгуй болгох шаардлагатай байна.

### Улсын төсвийн хөрөнгө оруулалт.

3.2.16 Монгол Улсын 2013 оны өсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3,189.1 тэрбум өгрөгийн төсөвт өртөг бүхий 1225 арга хэмжээнд 1,550.2 тэрбум өгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд 2013 оны өсвийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар 253 төсөл, арга хэмжээ хасагдаж, хөрөнгө оруулалтын төсөвт өртөг 527.0 тэрбум, санхүүжүүлэх дүн 425.9 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна.

3.2.17 Хөрөнгө оруулалтад батлагдсан төсөл, арга хэмжээг бүтцээр нь авч үзвэл, барилга байгууламж барихад 894.5 сая, тоног өхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авахад 103.7 сая, их засварын зардалд 46.3 сая, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад 79.8 сая төгрөг зарцуулахаар баталжээ.

3.2.18 2013 онд улсын өсвийн хөрөнгө оруулалтаар 2,661.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,124.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээс 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 787.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 336.5 тэрбум төгрөгийн эрх нээгдээгүй үлджээ. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг тусад нь тайлагнасан болно.

## 3.3 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

3.3.1 Орон нутгийн өсвийн нийт зарлага 2013 онд 1,769.9 тэрбум төгрөг буюу 87.1 хувийн үйцэтгэлтэй гарч, 261.9 тэрбум өгрөгийн хэмнэлттэй гарсныг үснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, Хэмнэлт	Хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,031.8</b>	<b>1,769.9</b>	<b>261.9</b>	<b>87.1</b>
Урсгал зардлын дүн	1,453.8	1,362.2	91.6	93.7
Бараа үйлчилгээний зардал	1,180.5	1,107.6	72.9	93.8
Зээлийн үйлчилгээний төлбөр	0.8	0.8	-	100.0
Татаас ба урсгал шилжүүлэг	272.6	253.8	18.8	93.1
Хөрөнгийн зардал	577.9	407.7	170.3	70.5

3.3.2 Улсын нэгдсэн төсвийн зарлагад орон нутгийн төсвийн зарлага 2 8.7 хувьд хүрч өмнөх оноос 16.3 пунктээр өсчээ.

3.3.3 Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал 77.2 хувийг, хөрөнгийн зардал 22.8 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс урсгал зарлага 1.1 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 157.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зарцуулалттай холбоотой байна. Аймаг, нийслэлийн төсвийн 2013 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

(тэрбум төгрөгөөр)

Аймаг, нийслэлийн нэр	Төсвийн зарлага			Аймаг, нийслэлийн нэр	Төсвийн зарлага		
	Төл	Гүйц	Зөрүү		Төл	Гүйц	Зөрүү
Архангай	57.9	55.0	-2.9	Сүхбаатар	45.3	44.2	-1.1
Баян-Өлгий	63.7	62.4	-1.3	Сэлэнгэ	64.2	61.8	-2.4
Баянхонгор	59.4	57.4	-2.0	Төв	63.0	61.0	-2.0
Булган	51.4	44.3	-7.1	Увс	57.8	56.3	-1.5
Говь-Алтай	52.5	46.7	-5.8	Ховд	58.3	55.8	-2.5
Дорноговь	43.7	43.1	-0.6	Хөвсгөл	81.6	77.8	-3.8
Дорнод	50.2	46.3	-3.9	Хэнтий	52.6	50.9	-1.7
Дундговь	37.3	32.5	-4.8	Дархан-Уул	50.4	47.2	-3.2
Завхан	54.1	53.4	-0.7	Улаанбаатар	851.5	681.6	-169.9
Өвөрхангай	65.7	62.6	-3.1	Орхон	70.7	47.0	23.7
Өмнөговь	83.4	67.0	-16.4	Говь-Сүмбэр	16.9	15.2	-1.7
<b>Бүгд дүн</b>					<b>2,031.8</b>	<b>1,769.9</b>	<b>-261.9</b>

3.3.4 Тайлант онд орон нутгийн төсвийн урсгал зарлага нь өмнөх оноос 1,260.0 тэрбум төгрөгөөр өсч 1,769.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 635.6 тэрбум төгрөг буюу 48.8 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 404.9 тэрбум төгрөг буюу 30.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 292.9 тэрбум буюу 21.2 хувийг татаас, урсгал шилжүүлэгийн зардал тус тус эзэлж байна.

3.3.5 Хөрөнгийн зардал өмнөх оноос 161.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 407.7 тэрбум төгрөгт хүрсэн нь орон нутгийн дотоод зүгсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.4 Хүний хөгжил сангийн зардлын гүйцэтгэл

3.4.1 2013 онд хүний хөгжил сангаас 282.8 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас 278.3 тэрбум төгрөг зарцуулж, 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын задаргааг хүснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1. Нийт зарлагын дүн</b>	<b>282.8</b>	<b>278.3</b>	<b>(4.5)</b>
2.1. Хүүхдийн мөнгө	234.0	229.0	(5.0)
2.2. Эх орны хувь хишиг	28.0	28.6	0.6
2.3. Төр хариуцах ЭМД-ын шимтгэл	12,151.5	12,151.5	-
2.4. ЗГ-ын бондын зээлийн үү	8.6	8.5	(0.1)
2.5. Банкны үйлчилгээний хураамж		0.2	0.2

3.4.2 2013 онд иргэн бүрт сар бүр олгох 21.0 мянган төгрөгийн хишиг хувийн үлдэгдлийг нөхөн олгоход 263462 иргэнд 28.0 тэрбум төгрөг олгохоор баталсан боловч гүйцэтгэлээр 0.6 тэрбум төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь урьд онд хишиг хувиа аваагүй иргэд болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн олгосонтой холбоотой байна.

3.4.3 2013 онд нийт 1.3 сая иргэдийн төрөөс хариуцах ЭМДШ-ийн төлбөрт 12.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

3.4.4 “Засгийн газрын нүхэт цаас гаргах тухай” УИХ -ын 2012 оны 64 үдээр тогтоолын дагуу 2012 оны эцэст гаргасан Засгийн газрын 1 жилийн хугацаатай, жилийн 8.0 хувийн хүүтэй бондын жүүгийн зардалд 8.6 тэрбум төгрөг төлсөн байна.

### 3.5 Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл

3.5.1 Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг үндэслэн НДҮЗ -ийн 2013 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн зарлагыг нийт 1,067.8 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.5.2 2013 онд Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 4,340.7 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 1,034.8 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардалд нийт 23.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

/тэрбум төгрөгөөр/

	Сангийн төрлөөр	2013 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	813.9	811.3	(2.6)	99.7
2	Тэтгэмжийн даатгал	57.5	58.7	1.2	102.0
3	ҮОМШӨ-ний даатгал	31.9	29.1	(2.8)	91.1
4	Ажилгүйдлийн даатгал	14.1	14.9	0.8	106.0
5	Эрүүл мэндийн даатгал	126.7	120.9	(5.8)	95.4
6	Үйл ажиллагааны зардал	18.4	18.0	(0.4)	98.2
7	Хөрөнгө оруулалт	5.4	5.3	(0.1)	97.6
	<b>ДҮН</b>	<b>1,067.8</b>	<b>1,058.1</b>	<b>(9.7)</b>	<b>99.1</b>

3.5.3 Тайлант хугацаанд НДС-гаас тэтгэмжийн даатгал, ажилгүйдлийн даатгалаас бусад зардлыг 0.1-5.8 тэрбум төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

3.5.4 Ажилгүйдлийн даатгалын сан 0.8 тэрбум төгрөгөөр өссөн нь “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг өхөн тооцох тухай” хуулийг шинээр хэрэгжүүлсэн, төрөлт ихэссэнтэй холбоотойгоор жирэмсэний ба амаржсаны тэтгэмж нэмэгдсэн, эдийн засгийн хямралаас үүдэн ажиллах хүчээ цомхотгосноос ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өссөн зэрэгтэй холбоотой байна.

3.5.5 2013 онд НДС-гаас хөрөнгө оруулалтад 5.37 тэрбум өгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 5.24 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/тэрбум төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Барилга байгууламж, их засвар	4.21	4.10	0.11	97.32
Тоног төхөөрөмж	0.52	0.51	0.01	98.82
Авто тээврийн хэрэгсэл	0.34	0.33	0.01	97.05
Тавилга эд хогшил	0.30	0.30	0	100.0
<b>НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>5.37</b>	<b>5.24</b>	<b>0.13</b>	<b>97.64</b>

3.5.6 Тайлант онд НДХ-ийн барилга объектод 3.29 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 0.79 тэрбум төгрөгийн их засварын ажил, гадна талбайн тохижилтод 0.02 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

### 3.6 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

3.6.1 2013 онд нэмэлт төсвөөр нийт 179.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна. Үүнд.

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 48.0 тэрбум төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 46.8 тэрбум төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37.0 тэрбум төгрөг,
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 31.7 тэрбум төгрөг,
- УИХ-аас баталсан ЗГ хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авсан нөөцлөлттэй зээл 9.5 тэрбум төгрөг,
- Төсвийн урамшууллаас 6.4 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

3.6.2 Тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 166.9 тэрбум төгрөгийг зарцуулсан ба үүнээс нийт зарлагын 97 хувь буюу 162.1 тэрбум төгрөгийг урсгал зардал, 3 хувь буюу 4.8 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.


3.6.3 Урсгал зардлын 9.0 хувь буюу 14.7 тэрбум төгрөгийг татаас, шилжүүлэг хэлбэрээр, 5.0 хувь буюу 7.5 тэрбум төгрөгийг цалин болон түүнтэй холбогдох зардалд, үлдсэн 86.0 хувь буюу 140.0 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

## БҮЛЭГ 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл

4.1 УИХ 2013 онд нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 1,560.4 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцэл 487.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.

4.2 2013 оны нэгдсэн өс вийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл 1,384.1 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 224.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

4.3 Төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 7.8 хувь, нийт тэнцлийн алдагдал ДНБ-ий 1.2 хувьтай тэнцэж байна. Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэлийг харуулбал,



4.4 Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2,597.9 тэрбум төгрөгийн ЗГ-ын үнэт цаас арилжаалсан ба мөн 321.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авсан бөгөөд өмнөх онд гаргасан ЗГ-ын үнэт цаасны үндсэн төлбөрт 1,558.4 тэрбум төгрөг, өмнөх оны гадаад болон дотоод зээлийн үндсэн төлбөрт 98.4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

4.5 Нэгдсэн төсвийн алдагдлыг юехэх эх үүсвэрээс үлдсэн 76.5 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн орлогод тооцон, төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 961.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.6 Харин Улсын төсвийн урсгал тэнцэл 743.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 608.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал тэнцэл 412.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 672.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

4.7 Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2,542.2 тэрбум төгрөгийн ЗГ-ын үнэт цаас арилжаалж үндсэн төлбөрт 1,450.3 тэрбум төгрөгийг төлснөөр улсын төсвийн алдагдалд 1,091.9 тэрбум төгрөгийн үнэт цаасыг авч ашигласны үр дүнд улсын төсвийн харилцах болох хадгаламжийн дансны үлдэгдэл 641.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.8 Орон нутгийн төсвийн нийт тэнцэл 166.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч үүнийг харилцах болон хадгаламж дансны үлдэгдлээр санхүүжүүлэхээр өлөвлөсөн ба гүйцэтгэлээр нийт тэнцэл 107.5 тэрбум төгрөгийн ашигтай гарч, энэ хэмжээгээр орон нутгийн харилцах болон хадгаламж дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

4.9 Хүний хөгжил сангийн нийт тэнцэл 114.8 тэрбум төгрөгийн ашигтай гар ахаар төлөвлөж гүйцэтгэлээр нийт тэнцэл 115.2 тэрбум төгрөгийн ашигтай гарч ЗГ-ын гаргасан үнэт цааснаас 55.7 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

4.10 Дээрх эх үүсвэрээс 108.1 тэрбум төгрөгийг өмнөх онд гаргасан ЗГ-ын үнэт цаасны үндсэн төлбөрт төлж, 76.5 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн орлогод тооцсоноос харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 13.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

4.11 Нийгмийн даатгалын сангийн нийт тэнцэл 172.3 тэрбум төгрөгийн ашигтай гарахаар төлөвлөж гүйцэтгэлээр 225.3 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл нь мөн дүнгээр нэмэгдсэн байна.

## БҮЛЭГ 5. Дүгнэлт

Монгол Улсын 2013 оны нэгдсэжүсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр УИХ -аас баталсан Төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийн нэгээс бусдыг хангасан байна.
2. 2013 оны нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 1,384.1 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 224.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,940.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь анх батлагдсан төлөвлөгөөнөөс 1,148.2 тэрбум төгрөгөөр, тодотгосон төлөвлөгөөнөөс 459.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.
4. Нэгдсэн төсвийн зарлага 6,164.7 тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас 722.0 тэрбум төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь төсвийн орлогыг тодотгосон түвшинд бүрдүүлж чадаагүйтэй холбоотой байна. Нийт зардалд урсгал зардал 73.8 хувийг, хөрөнгийн зардал 24.2 хувийг, эргэн төлөгдөх цэвэр зээл 2.0 хувийг тус тус эзэлж байна.
5. 2013 оны Төсвийн тухай хуулиар ТЕЗ-дын үндсэн чиг үүрэгт хамаарах 101 хөтөлбөрийн 304 арга хэмжээг хүрэх үр дүн, зорилтот түвшинээр нь баталсан боловч арга хэмжээний өлөвлөлт нь санхүүжилттэй уялдаагүй, хэрэгжилтийг санхүүжилт болон хүрэх түвшинтэй харьцуулан үнэлэх боломжгүй байна.
6. Орон нутгийн төсөвт 1,901.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж 1,769.9 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээр нэгдсэн төсвийн зардалд орон нутгийн төсвийн эзлэх хувь хэмжээ 28.7 хувь болж өмнөх оныхоос 3.4 дахин нэмэгдсэн байна.

## БҮЛЭГ 6. Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

### Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танаа

1. УИХ-аас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд заасан орлогын түвшинг хангаагүй байгааг тусгайлан авч үзэж дүгнэлт гаргах, Татвар төлөгчдийн орлогын бууралттай уялдсан төсвийн орлогын эрсдлийг багасгах, төрийн өмчийн хөрөнгө, байгалийн баялгаас орох орлогыг нэмэгдүүлэх замаар нэгдсэн төсвийн орлогын бүтцийг оновчтой болгоход чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх
2. Хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас авах тусламжийн орлого, хөнгөлттэй зээлийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох, ашиглалт, зарцуулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого боловсруулах, шаардлагатай арга хэмжээ авах
3. Улс, орон нутгийн төсвийн урсгал зардал, ялангуяа удирдлагын зардлыг бууруулах талаар бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Төсвийн тухай хуулийн дагуу өтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт, хяналт, тайлагналын горимыг хэрэгжүүлэх.
4. Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах
5. Эргэн өлөгдөх цэвэр зээлийн хэлбэрээр төсвийн орлогод хийсвэрээр төлөвлөгдөж байгаа найдваргүй авлагыг барагдуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах



Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

(сая төгрөгөөр)

Төсвийн орлогын нэр	Уулзас:														
	Орлогын нэгдсэн дүн			Улсын төсөө			Орон нутгийн төсөө			Хүний хөгжил сан			Нийгмийн даатгалын сан		
	төлөө-лөвөө	гуйцэтгэл	зөрүү	төлөө-лөвөө	гуйцэтгэл	зөрүү	төлөө-лөвөө	гуйцэтгэл	зөрүү	төлөө-лөвөө	гуйцэтгэл	зөрүү	төлөө-лөвөө	гуйцэтгэл	зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,448,550.5</b>	<b>5,986,925.3</b>	<b>(461,625.2)</b>	<b>4,606,418.6</b>	<b>4,057,257.2</b>	<b>(549,161.4)</b>	<b>1,890,008.9</b>	<b>1,901,668.0</b>	<b>11,659.1</b>	<b>397,580.8</b>	<b>393,534.9</b>	<b>(4,045.9)</b>	<b>1,240,113.7</b>	<b>1,283,389.1</b>	<b>43,275.4</b>
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	48,965.2	46,858.6	(2,106.6)	48,965.2	46,858.6	(2,106.6)	-	-	-	-	-	-	-	-	-
2. УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	7,554.4	7,554.4	-	7,554.4	7,554.4	-	-	-	-	-	-	-	-	-	-
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	13,265.8	10,839.2	(2,426.6)	13,265.8	10,839.2	(2,426.6)	-	-	-	-	-	-	-	-	-
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	28,145.0	28,465.0	320.0	28,145.0	28,465.0	320.0	-	-	-	-	-	-	-	-	-
<b>НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,399,585.3</b>	<b>5,940,066.7</b>	<b>(459,518.6)</b>	<b>4,557,453.4</b>	<b>4,010,398.6</b>	<b>(547,054.8)</b>	<b>1,890,008.9</b>	<b>1,901,668.0</b>	<b>11,659.1</b>	<b>397,580.8</b>	<b>393,534.9</b>	<b>(4,045.9)</b>	<b>1,240,113.7</b>	<b>1,283,389.1</b>	<b>43,275.4</b>
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	6,397,457.6	5,936,672.9	(460,784.7)	4,443,017.3	3,896,448.3	(546,569.0)	733,252.7	772,460.5	39,207.8	397,580.8	393,534.9	(4,045.9)	974,537.5	1,018,812.9	47,275.4
1. Татварын орлого	5,680,091.5	5,072,793.3	(607,298.1)	3,871,253.1	3,196,869.2	(674,384.0)	655,956.3	676,656.1	20,699.8	329,275.2	325,038.9	(4,236.3)	974,537.5	1,018,812.9	47,275.4
1.1 Орлогын албан татвар	1,302,443.6	1,109,204.9	(193,238.7)	863,754.0	660,159.0	(203,595.0)	438,689.6	449,045.9	10,356.3	-	-	-	-	-	-
1.1.1 Хувь хүний орлогын	438,689.6	449,045.9	10,356.3	-	-	-	438,689.6	449,045.9	10,356.3	-	-	-	-	-	-
1.1.2 ААН, байгууллагын	863,754.0	660,159.0	(203,595.0)	863,754.0	660,159.0	(203,595.0)	-	-	-	-	-	-	-	-	-
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	823,606.8	874,229.2	50,622.4	-	-	-	-	-	-	-	-	-	971,537.5	1,018,812.9	47,275.4
1.3 Өнцийн татвар	35,581.3	43,975.4	8,394.1	-	-	-	35,581.3	43,975.4	8,394.1	-	-	-	-	-	-
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,764,832.0	1,435,091.6	(329,740.4)	1,764,832.0	1,435,091.6	(329,740.4)	-	-	-	-	-	-	-	-	-
1.5 Онцгой албан татвар	455,775.8	449,410.3	(6,365.5)	455,775.8	449,410.3	(6,365.5)	-	-	-	-	-	-	-	-	-
1.6 Тусгай зориулалтын орлого	35,433.2	36,688.4	1,255.2	10,619.0	10,908.2	289.2	24,814.2	25,780.2	966.0	-	-	-	-	-	-
1.7 Гаалийн албан татвар	516,606.5	381,427.0	(135,179.5)	516,606.5	381,427.0	(135,179.5)	-	-	-	-	-	-	-	-	-
1.8 Бусад татвар	745,812.3	742,766.6	(3,045.7)	259,665.8	259,873.1	207.3	156,871.3	157,854.6	983.3	329,275.2	325,038.9	(4,236.3)	-	-	-
2. Татварын бус орлого	717,366.2	863,879.6	146,513.4	571,764.2	699,579.2	127,815.0	77,296.4	95,804.4	18,506.0	68,305.6	68,496.0	190.4	-	-	-
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2,127.6	3,393.7	1,266.1	-	-	-	2,127.6	3,393.7	1,266.1	-	-	-	-	-	-
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	-	-	114,436.1	113,950.3	(485.8)	1,154,628.6	1,125,813.8	(28,814.8)	-	-	-	266,576.2	264,576.2	(4,000.0)

МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Зарлагын нэгдсэн бүтэц		Улсын төсөв		Орон нутагийн төсөв		Хүний хөгжил сэн		Нийгмийн баялагын сэн			
	төлөв-лөвөө	аудитал зөрүү	төлөв-лөвөө	аудитал зөрүү	төлөв-лөвөө	аудитал зөрүү	төлөв-лөвөө	аудитал зөрүү	төлөв-лөвөө	аудитал зөрүү		
<b>НИЙТ ЗАРЛАГ БА ЦЭВЭР ЭЗЭСЭЙН ДҮН</b>	<b>6,886,652.1</b>	<b>6,164,695.3</b>	<b>4,683,038.2</b>	<b>(482,530.5)</b>	<b>2,056,048.7</b>	<b>1,794,118.8</b>	<b>(201,929.9)</b>	<b>282,799.5</b>	<b>(4,459.9)</b>	<b>1,067,806.9</b>	<b>1,058,112.8</b>	<b>(9,694.1)</b>
Баруун, үнчлэгэний зардал	4,837,088.0	4,592,806.6	3,493,988.7	(216,352.0)	1,478,155.6	1,386,445.3	(91,670.3)	282,799.5	(4,459.9)	1,062,423.8	1,062,857.0	(9,566.9)
Цэвэр, үнчлэгэний зардал	2,562,383.3	2,391,174.1	1,338,930.9	(10,092.4)	1,180,466.4	1,107,951.2	(72,515.2)	0.2	0.2	18,016.5	17,462.6	(553.9)
Цэвэр, үнчлэгэний зардал	1,418,689.6	1,401,501.8	795,824.0	(15,777.5)	635,670.9	633,397.8	(2,273.1)	-	-	12,417.2	12,309.0	(108.2)
Нийгмийн даатгалын шилгэл, зэрэглэл	135,772.9	132,430.8	63,416.2	(2,274.4)	70,071.0	69,179.4	(891.6)	-	-	2,288.8	2,193.7	(95.1)
Үйлчилгээний бүсэд зардал	1,142,703.7	999,643.3	581,623.2	(63,036.4)	474,724.5	404,974.0	(69,750.5)	0.2	0.2	3,313.6	3,860.8	547.2
Зөвлөлийн үйлчилгээний төлбөр	313,794.0	270,442.1	261,080.0	(43,282.7)	773.3	771.7	(1.6)	8,648.0	(67.6)	-	-	-
Талаас барууны шилжүүлэг	1,969,820.7	1,890,930.3	1,824,207.8	(70,976.9)	286,876.8	278,922.4	(8,754.4)	274,151.5	(4,382.5)	1,044,407.3	1,035,394.4	(9,012.9)
ХЭРЭГЧИЙН ЗЭРДЭЛ	1,959,970.8	1,490,741.7	1,077,912.5	(398,842.1)	577,932.2	407,673.4	(170,259.8)	-	-	5,383.0	5,255.8	(127.2)
Урьдчилан зардал	1,594,861.9	1,102,638.7	747,205.6	(330,772.4)	512,403.7	351,180.1	(161,223.6)	-	-	4,860.2	4,453.0	(407.2)
2-ийн саяар зардал	101,175.9	98,079.0	40,328.0	(15,395.2)	54,045.9	46,348.2	(7,697.7)	-	-	802.8	802.8	0.0
3-ийн саяар зардал	60,716.5	45,700.6	43,865.4	(14,621.3)	2,428.8	2,035.2	(393.6)	-	-	-	-	-
4-ийн саяар зардал	313,794.0	270,442.1	261,080.0	(43,282.7)	773.3	771.7	(1.6)	8,648.0	(67.6)	-	-	-
Өөрөөр өөрсөж зардал	203,117.5	254,123.4	246,013.5	51,950.8	9,054.8	8,109.9	944.9	-	-	-	-	-
1-Эргэх төлбөр долоод цээр эзэл	88,673.3	121,337.0	121,337.0	31,663.7	-	-	-	-	-	-	-	-
2-Эргэх төлбөр долоод цээр эзэл	22,355.1	104,701.5	104,701.5	82,346.4	-	-	-	-	-	-	-	-
3-Эргэх төлбөр долоод цээр эзэл	67,318.2	16,635.5	16,635.5	(50,682.7)	-	-	-	-	-	-	-	-
<b>Төсвийн тэнцэл УРСГАЛ</b>	<b>1,560,449.6</b>	<b>1,384,066.3</b>	<b>412,559.6</b>	<b>(331,216.9)</b>	<b>(744,862.8)</b>	<b>(613,984.8)</b>	<b>130,878.0</b>	<b>114,781.3</b>	<b>414.1</b>	<b>(90,886.4)</b>	<b>(34,044.1)</b>	<b>56,842.3</b>
<b>НИЙТ АЯДАГ ДАВЬСАН ХҮҮЖИЛГЭХ</b>	<b>(487,066.9)</b>	<b>(224,618.7)</b>	<b>(672,639.6)</b>	<b>(64,524.3)</b>	<b>(166,039.7)</b>	<b>(107,549.2)</b>	<b>58,490.5</b>	<b>114,781.3</b>	<b>414.1</b>	<b>172,306.8</b>	<b>225,276.3</b>	<b>52,969.5</b>
Хариуцаж болон хадгалсангийн даноги цээр өөрчлөлт	487,066.9	224,618.7	672,639.6	64,524.3	166,039.7	107,549.2	(273,586.9)	(114,781.3)	414.1	(172,306.8)	(225,276.3)	(52,969.5)
ЗГ-ын бонд	(478,799.9)	(946,180.8)	(641,941.7)	(183,408.3)	166,039.7	(107,549.2)	(273,586.9)	28,586.5	28,586.5	(172,306.8)	(225,276.3)	(52,969.5)
Эрх зүйн агаар	817,615.7	1,039,436.9	1,039,436.9	221,821.2	845,629.1	1,035,912.7	186,283.6	(52,384.3)	(52,384.3)	(62,426.6)	(42.3)	-
Дотоод	797,244.8	983,486.1	845,629.1	(137,857.0)	845,629.1	1,035,912.7	186,283.6	(52,384.3)	(52,384.3)	(62,426.6)	(42.3)	-
Шинээр гаргах	1,141,415.7	1,091,686.1	1,085,700.0	(45,823.6)	1,085,912.7	(49,787.3)	-	95,715.7	95,715.7	56,673.4	(42.3)	-
Урьдчилан зардал	(344,170.9)	(108,100.0)	(236,070.9)	(236,070.9)	-	-	-	(108,100.0)	(108,100.0)	-	-	-
Гаднаад	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилан зардал	20,370.9	55,950.8	55,950.8	35,579.9	-	-	-	-	-	-	-	-
Дотоод	20,370.9	55,950.8	55,950.8	35,579.9	-	-	-	-	-	-	-	-
Шинээр гаргах	1,471,000.0	1,596,263.4	1,471,000.0	15,263.4	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилан зардал	(1,450,629.1)	(1,450,629.1)	(1,450,629.1)	(1,450,629.1)	310.6	(1,450,318.5)	310.6	-	-	-	-	-
ЗГ-ын эзэл	210,648.0	222,717.8	222,717.8	12,069.8	-	-	-	-	-	-	-	-
Дотоод	(2,684.0)	(3,753.0)	(3,753.0)	(1,069.0)	-	-	-	-	-	-	-	-
Монголбанк (СНБС)	(2,684.0)	(3,753.0)	(3,753.0)	(1,069.0)	-	-	-	-	-	-	-	-
Шинээр гаргах	(2,684.0)	(3,753.0)	(3,753.0)	(1,069.0)	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилан зардал	213,332.0	226,470.8	226,470.8	13,138.8	-	-	-	-	-	-	-	-
Төслийн эзэл	298,080.8	321,102.0	321,102.0	23,021.2	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилан зардал	(84,748.8)	(94,631.2)	(94,631.2)	(9,882.4)	-	-	-	-	-	-	-	-
Хөтөлбөрийн эзэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилан зардал	(62,387.0)	91,952.2	-	-	-	-	-	(62,387.0)	-	(76,540.2)	-	-
Тооцогдоог	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бүтэц	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Нэгдсэн төслийн дүн		Үүнээс:				Хүний хөгжлийн сан		Нийгмийн даатгалын сан	
	мөнгөлөгөө	гүйцэтгэл	Улсын төсөө	Орон нутгийн төсөө	Хүний хөгжлийн сан	Нийгмийн даатгалын сан	мөнгөлөгөө	гүйцэтгэл	мөнгөлөгөө	гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,448,550.5	5,986,925.3	4,606,418.6	4,057,257.2	397,580.8	393,535.0	1,240,113.7	1,283,389.1		
ТОГТВОРЖИЛТИЙН САН	48,965.2	46,858.6	48,965.2	46,858.6						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,399,585.3	5,940,066.7	4,557,453.4	4,010,398.6	397,580.8	393,535.0	1,240,113.7	1,283,389.1		
Урсгал орлогын дүн	6,397,457.6	5,936,672.9	4,443,017.3	3,896,448.3	397,580.8	393,535.0	971,537.5	1,018,872.9		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,886,652.1	6,164,685.3	5,165,568.7	4,683,038.2	282,799.5	278,339.6	1,067,806.9	1,058,112.8		
Үүнээс: урсгал зарлагын дүн	4,837,008.0	4,552,606.6	3,699,240.7	3,483,888.7	1,478,115.6	1,386,445.3	1,062,423.8	1,052,857.0		
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ: урсгал	1,560,449.6	1,384,066.3	743,776.6	412,559.6	(744,862.8)	(613,984.8)	(90,886.3)	(34,044.1)		
нийт	(487,066.8)	(224,618.6)	(608,115.3)	(672,639.6)	107,549.2	114,781.3	172,306.8	225,276.3		
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ӨХ ҮҮСВЭР	487,066.8	224,618.7	608,115.2	672,639.6	166,039.7	(107,549.2)	(172,306.8)	(225,276.3)		
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(478,799.9)	(960,995.8)	(472,532.8)	(641,941.7)	166,039.7	(107,549.2)	(172,306.8)	(225,276.3)		
2. Засгийн газрын бонд	817,615.7	1,039,436.9	870,000.0	1,091,863.5						
2.1. Урт хугацаат	797,244.8	983,486.1	849,629.1	1,035,912.7						
2.1.1. Дотоод шинээр гаргах	1,141,415.7	1,091,586.1	1,085,700.0	1,035,912.7						
2.1.2. Үндсэн төлбөр	(344,170.9)	(108,100.0)	(236,070.9)							
2.1.1.1 Шинээр гаргах	20,370.9	55,950.8	20,370.9	55,950.8						
2.1.1.2 Дотоод шинээр гаргах	1,471,000.0	1,506,269.4	1,471,000.0	1,506,269.4						
2.1.2. Үндсэн төлбөр	(1,450,629.1)	(1,450,318.6)	(1,450,629.1)	(1,450,318.6)						
3. Засгийн газрын зээл	210,648.0	222,717.8	210,648.0	222,717.8						
3.1. Дотоод	(2,684.0)	(3,753.0)	(2,684.0)	(3,753.0)						
3.1.1.Монгол банк (ОУВС)	(2,684.0)	(3,753.0)	(2,684.0)	(3,753.0)						
3.1.1.1 Шинээр гаргах	-	-	-	-						
3.1.1.2 Үндсэн төлбөр	(2,684.0)	(3,753.0)	(2,684.0)	(3,753.0)						
3.1.2.Монгол банк (Дэлхийн банк)	-	-	-	-						
3.2. Гаднаад	213,332.0	226,470.8	213,332.0	226,470.8						
3.2.1.Төслийн зээл	213,332.0	226,470.8	213,332.0	226,470.8						
3.2.1.1 Шинээр авах	298,080.8	321,102.0	298,080.8	321,102.0						
3.2.1.2 Үндсэн төлбөр	(84,748.8)	(94,631.2)	(84,748.8)	(94,631.2)						
Урьдчилгаа орлогоос орлогод тооцогдсо	(62,397.0)	(76,540.2)								
5. Өмч хуучлал										



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2015 оны 5 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайдад зөвлөсүгэй.
5. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга С.Төмөрхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



*(Handwritten signature)*

А.ЗАНГАД